



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/12

Шивээговь сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Засаг даргын 2021 оны А/04 дугаар “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” захирамжаар Хаялга нуурын баруун талд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 28 иргэнд олгосон 1,4 га газрыг хүчингүй болгосон захирамж нь Захиргааны ерөнхий хуульд заасан ажиллагаа хийгдээгүй тул тус иргэдийн газар эзэмших эрхийг хэвээр үлдээсүгэй.

2. Энэхүү захирамжийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт мэдэгдэхийг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны А/04 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ

